



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах хуваарь батлах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.4 дэх заалт, 24.6 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах журам”-ын 2.3.1, 2.3.2 дахь заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж зам, талбай, гэр болон орон сууцны хорооллын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2026 онд нийслэлийн хэмжээнд зохион байгуулах бүх нийтийн их цэвэрлэгээний хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2.Дүүргийн нутаг дэвсгэрт их цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулан, удирдамж хуваарь, төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд хяналт тавьж, харьяа газар болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг цэвэрлэгээнд бүрэн хамруулж оролцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг нэгдсэн чиг үүргээр хангаж, тайлан, дүн мэдээг тухай бүр танилцуулж, ажлаа сурталчилж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын газар (Г.Билгүүн)-т даалгасугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн удирдлагын газар (Н.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Г.БАТЗОРИГ



1726010004

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2026 оны 02 дугаар сарын 05 өдрийн
тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД 2026 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮХ НИЙТИЙН
ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ХУВААРЬ

Д/д	Цэвэрлэгээний хуваарь	Цэвэрлэгээ зохион байгуулах хугацаа	Хариуцан зохион байгуулах мэргэжилтэн	Албан тушаал
1	Сар шинийн баярыг угтсан Бүх нийтийн их цэвэрлэгээ	2026 оны 02 дугаар сарын 13, 14-ний өдөр	Ш.Батпүрэв	ОБХХУХ-ийн Ахлах мэргэжилтэн
2	Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ	2026 оны 04 дүгээр сарын 10, 11-ний өдөр	Б.Мөнхжаргал	ОБХХУХ-ийн мэргэжилтэн
3	Хүүхдийн баярыг угтсан их цэвэрлэгээ	2026 оны 05 дугаар сарын 22, 23-ны өдөр	Г.Индаръяа	ОБХХУХ-ийн мэргэжилтэн
4	Үндэсний Их Баяр наадмыг угтсан хог хаягдал, шарилж, лууль цэвэрлэгээ	2026 оны 07 дугаар сарын 03, 04-ний өдөр	Д.Шийтэр	ОБХХУХ-ийн мэргэжилтэн
5	Хичээлийн шинэ жилийг угтсан бүх нийтийн цэвэрлэгээ	2026 оны 08 дугаар сарын 21, 22-ны өдөр	Ш.Батпүрэв	ОБХХУХ-ийн Ахлах мэргэжилтэн
6	Намрын бүх нийтийн их цэвэрлэгээ, "Их дэлхийн цэвэрлэгээний өдөр" бүх нийтийн арга хэмжээ	2026 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр	Б.Мөнхжаргал	ОБХХУХ-ийн мэргэжилтэн
7	Өвөлжилтийн бэлэн байдлыг хангах Бүх нийтийн их цэвэрлэгээ	2026 оны 11 дүгээр сарын 13, 14-ний өдөр	Г.Индаръяа	ОБХХУХ-ийн мэргэжилтэн
8	Шинэ жилийн баярыг угтсан хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийг эрчимжүүлэх, зам талбайн халтиргаа, гулгааг арилгах цэвэрлэгээ	2026 оны 12 дугаар сарын 18, 19-ний өдөр	Д.Шийтэр	ОБХХУХ-ийн мэргэжилтэн

